



## МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

2014 оны 05-р дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. "Монголын авто замчдын холбоо" төрийн бус байгууллага (цаашид МАЗХ гэж товчилно) нь Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Төрийн бус байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллах гишүүддээ үйлчилдэг ашгийн төлөө бус төрийн бус байгууллага мён.
- 1.2. МАЗХ -ны оноосон нэр нь англиар "Mongolian Road Association"
- 1.3. МАЗХ-ны албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-11 тээврийн үйлчилгээний байр 401 тоот.
- 1.4. МАЗХ нь Монгол Улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд бүртгүүлсэнээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.
- 1.5. МАЗХ нь өөрийн тэмдэг, бэлгэдэл, данс, албан бичгийн нүүртэй байна.
- 1.6. МАЗХ нь өөрийн нэрэмжит одон, шагналтай байна.
- 1.7. МАЗХ нь дүрмийг баталсан өдөр нь түүний үүсгэн байгуулагдсанд тооцогдох болно.
- 1.8. МАЗХ нь Монгол Улсын аймаг, суманд болон гадаад улсуудад өөрийн салбартай байж болно.
- 1.9. МАЗХ нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан, тэнцэл, үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд гаргаж өгнө.

### Хоёрдугаар зүйл. Зорилго, үйл ажиллагааны чиглэл

- 2.1. МАЗХ -ны гол зорилго нь Авто замын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого үйл ажиллагааг боловсруулхад идэвхитэй оролцон салбарын хөгжлийг эрчимжүүлхэд хувь нэмэр оруулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, тэдэнд бодитой үйлчилгээ, туслалцаа үзүүлэхэд оршино.
- 2.2. МАЗХ нь энэхүү дүрмийн 2.1-д заасан зорилгоо хангахын тулд дараахь чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:
  - 2.2.1. Гишүүдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа эрхлэн явуулах;
  - 2.2.2. Гишүүдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудтай харьцах;
  - 2.2.3. Монгол улсын нутаг дэвсгэрт хууль зүйн дагуу албан ёсоор үйл ажиллагаа явуулж байгаа авто замын барилга угсралт, засвар арчлалт болон материалын үйлдвэрлэл, замын хайгуулын зураг төсөл, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
  - 2.2.4. Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд, салбарын төр захиргаа, төрийн бус байгууллагуудын зарим үйл ажиллагаанд хяналт тавин оролцох;
  - 2.2.5. Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд, салбарын төр захиргаа,

төрийн бус байгууллагууд тэдгээрт ажиллаж байгаа ажиллагадын эрх ашгийг хамгаалах

- 2.2.6. Авто замыг хөгжүүлэх талаар баримталж байгаа төр засгийн бодлого үйл ажиллагааг дэмжиж Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмаар болон бусад байдлаар Засгийн газар болон бусад төрийн байгууллагуутай хамтран ажиллах

### Гуравдугаар зүйл .Үйл ажиллагааны зарчим

- 3.1. МАЗХ ны зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан, нэгдмэл зарчимд тулгуурлана.
- 3.2. МАЗХ нь үйл ажиллагаандaa гишүүд, гишүүн байгууллагуудыг өмчийн хэлбэр, салбар болон нутаг дэвсгэрийн байршилыг ялгаварлахгүй зарчмыг баримтлана.
- 3.3. МАЗХ - ны дүрмийг хүлээн зөвшөөрсөн авто замын байгууллага, тэдгээрт ажиллагсад нь Авто замчдад тооцогдож холбооны гишүүнчлэл нь чөлөөтэй байх зарчим баримтлана.
- 3.4. МАЗХ нь Монгол улсын үндсэн хууль, төрийнбус байгууллагын тухай хууль бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 3.5. МАЗХ нь гадаадын болон олон улсын ижил төрлийн байгууллагад гишүүнээр элсэж хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг эрмэлзэнэ.
- 3.6. Төрийн ажлыг орлон гүйцэтгэхгүй, нам улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй, гишүүдийг нас, хүйс, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлахгүй.

### Дөрөвдүгээр зүйл. МАЗХ -ны бүтэц ,зохион байгуулалт хяналтын тогтолцоо

- 
- 4.1. МАЗХ нь өөрийн үйлажиллагааг нээлттэй, нийгмийн бүх гишүүдэд хүртээмжтэй байлгахын тулд дараахь бүтэцтэй байна. Үүнд:
    - 4.1.1. Их хурал
    - 4.1.2. Зөвлөлдөх хороо
    - 4.1.3. Удирдах зөвлөл
    - 4.1.4. Ерөнхийлөгч
    - 4.1.5. Хяналтын зөвлөл
    - 4.1.6. Гүйцэтгэх захирал.
    - 4.1.7. Ажлын алба.
  - 4.2. Үйлдвэрлэл болон нутаг дэвсгэрийн шинж байдлыг харгалзан МАЗХ-ны салбар зөвлөл байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн газар нутаг, үйлдвэрлэл ажиллаж байгаа ажиллагдын төлөөлийг оролцуулсан албан ёсны хурал цуглаанаар шийдвэрлэн тогтоол гаргаж МАЗХ-нд бүртгүүлнэ.
  - 4.3. Салбар зөвлөлүүд нь Авто замчдын их хурал, зөвлөлдөх хороо, удирдах зөвлөл, хянан шалгах комиссын шийдвэр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, МАЗХ-ны нэгдмэл удирдлага зөвлөлгөөг авч, тайлагнаж ажиллана.

### Тавдугаар зүйл. Их хурал

- 5.1. Их хурал нь холбооны эрх барих дээд байгууллага мөн.
- 5.2. Их хурал нь ээлжит болон ээлжит бус хуралтай байх бөгөөд ээлжит хурлыг 3 жил тутамд хуралдуулна.

- 5.3. Дүрэмд заасны дагуу ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
- 5.4. Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
  - 5.4.1. МАЗХ ны зөвлөлдөх хорооны ажлын тайлан болон салбарын хөгжлийн тулгамдсан асуудал
  - 5.4.2. МАЗХ -ны хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх
  - 5.4.3. МАЗХ ны дурэм, мөрийн хөтөлбөр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах.
  - 5.4.4. МАЗХ -ны зөвлөлдөх хорооны болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонго.
  - 5.4.5. МАЗХ-ны зөвлөлдөх хорооны 10 хүртэл гишүүнийг төр, олон нийтийн байгууллагаас квотоор оруулж болно.
  - 5.4.6. МАЗХ -ны ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх,
  - 5.4.7. МАЗХ -г өөрчлөн байгуулах, татан буулгах.

### **Зуравдугаар зүйл. Зөвлөлдөх хороо**

- 6.1. Их хурлаас зөвлөлдөх хорооны гишүүдийг томилох бөгөөд зөвлөлдөх хороо нь их хурлын чөлөө цагт холбооны үйл ажиллагааг 51 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлдөх хороо удирдана.
- 6.2. МАЗХ-ны зөвлөлдөх хороо жилд 1-ээс доошгүй удаа хуралдаж доор дурьдсан асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.
  - 6.2.1. МАЗХ-ны ерөнхийлөгч, тайланг хэлэлцэн, жилийн тесөв батлах
  - 6.2.2. МАЗХ -ны тухайн оны хөрөнгө санхүүгийн төлөвлөгөөг батлах, түүний зарцуулалт
  - 6.2.3. Жилийн болон ойрын жилүүдийн ажлын төлөвлөгөөг батлах
  - 6.2.4. Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох
  - 6.2.5. Хяналтын зөвлөлийн мэдээллийг сонсох
  - 6.2.6. МАЗХ-ны дэргэдэх сангийн дүрэм батлах төрийн бус байгууллагын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах;
  - 6.2.7. Бүрэн эрхийн хугацаанд зөвлөлдөх хорооны гишүүний 15 хүртэл хувийг чөлөөлөх
  - 6.2.8. МАЗХ ны ерөнхийлөгчийг чөлөөлөх хууль зүйн үндэслэл бий болсон гэж үзвэл Монголын авто замчдын ээлжит бус их хурлыг зөвлөлдөх хорооны бүх гишүүдийн дийлэнхи олонхийн /66% / шийдвэрээр хуралдуулж асуудлыг шийдвэрлэж болно.
  - 6.2.9. Цаг үеийн бусад асуудал

### **Долдугаар зүйл. Удирдах зөвлөл**

- 7.1. МАЗХ-ны удирдах зөвлөлийг зөвлөлдөх хорооны хурлаас 5-15 хүртэл хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгоно.
- 7.2. Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 жил байна.
- 7.3. Удирдах зөвлөлийн гишүүнийг зөвлөлдөх хорооны хурлаар сонгож , чөлөөлнө.
- 7.4. Удирдах зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдаж дараах асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.
  - 7.4.1. МАЗХ ны ажлын албаны орон тоо, цалингийн санг батлах.
  - 7.4.2. Улирлын ажлын төлөвлөгөө батлах.
  - 7.4.3. Цаг үеийн шаардлагатай бусад асуудал

### **Наймдугаар зүйл. МАЗХ-ны ерөнхийлөгч**

- 8.1. МАЗХ-ны ерөнхийлөгч нь 3 жилийн хугацаагаар их хурлаас сонгогдоно.

- 8.2. МАЗХ-ны ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхтэй байна.
- 8.2.1. Ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийн хамт их хурал, зөвлөлдөх хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
  - 8.2.2. Зөвлөлдөх хорооны хурлын бэлтгэлийг хангаж, удирдах
  - 8.2.3. МАЗХ ны ерөнхийлөгч нь холбоог гадаад, дотоодод төлөөлөхөөс гадна төр, аж ахуйн болон төрийн бус байгууллагатай үр нөлөөтэй хамтран ажиллах.
  - 8.2.4. МАЗХ-ны ажлын албыг удирдах, Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хяналт тавих
  - 8.2.5. Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулан хуралдуулж, хуралдааныг даргалах
  - 8.2.6. МАЗХ-ны үйл ажиллагаатай холбогдсон гомдол бусад асуудлыг шалгах ажлыг зохион байгуулах
  - 8.2.7. МАЗХ-ны өмч хөрөнгийг захиран зарцуулж тайлагнах
  - 8.2.8. Гишүүнийг шагнах, урамшуулах асуудлыг шийдвэрлэх
  - 8.2.9. Эрх хэмжээнийхээ асуудлаар эрх зүйн акт гаргах
  - 8.2.10. Удирдах зөвлөлийн гишүүн чөлөөлөгдсөн тохиолдолд түүний оронд сонгогдох иргэний нэрийг дэвшүүлэх,
  - 8.2.11. Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, Удирдах зөвлөлөөс сонгосон Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, түүнд зөвлөмж, зааварчилгаа егөх,
- 8.3. МАЗХ-ны ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болсноор удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно
- 8.4. МАЗХ-ны ерөнхийлөгч нь гүйцэтгэх захирлын албыг хавсран гүйцэтгэж болно.

### **Есдүгээр зүйл. Хяналтын зөвлөл**

- 9.1. Хяналтын зөвлөл нь МАЗХ-ны үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүгийн зохицуулалтад хяналт тавина.
- 9.2. МАЗХ-ны ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн түүнчлэн хөдөлмөрийн гэрээт ажиллагчдыг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгохгүй.
- 9.3. Хяналтын зөвлөл жилд 2 - оос доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд хэдийд ч хуралдаж болно.
- 9.4. Хяналтын зөвлөл үйл ажиллагаатайгаа холбогдсон аливаа мэдээ, бичиг баримтыг саадгүй гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүнийг хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулах эрхтэй.
- 9.5. Хяналтын зөвлөл илэрсэн дутагдлыг тухай бүр Зөвлөлдөх хороо болон Удирдах зөвлөлд мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авахуулна.

### **Аравдугаар зүйл. Гүйцэтгэх захирал**

- 10.1. Гүйцэтгэх захирлыг МАЗХ-ны удирдах зөвлөлийн хурлаас томилно.
- 10.2. Гүйцэтгэх захирал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 10.3. Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд МАЗХ-ны өдөр тутмын дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 10.4. Зөвлөлдөх хорооноос тогтоож өгсөн санхүүгийн төлөвлөгөөг удирдлага болгон удирдах зөвлөлийн хурлаар баталсан ажлын албаны орон тоо, бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажлын албыг бүрдүүлж удирдана.

### **Арваннэг дүгээр зүйл. Ажлын алба**

- 11.1. Гүйцэтгэх захирал нь ажлын төлөвлөгөөгөө гаргах явцдаа Ажлын алба байгуулан ажиллах зайлшгүй шаардлагатай болохыг тодорхойлж, Удирдах зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх үүрэгтэй.
- 11.2. Удирдах Зөвлөл Гүйцэтгэх захиралын саналыг үндэслэн ажлын албыг тодорхой бүрэлдэхүүнтэйгээр байгуулж болно.
- 11.3. Ажлын албыг түр болон байнгын гэсэн хугацаатайгаар байгуулах бөгөөд Удирдах зөвлөлийн Ажлын албыг байгуулах тухай тогтоолд энэ тухай заавал тусгасан байна.
- 11.4. Ажлын албыг Гүйцэтгэх захирал өөрөө даргалах, эсхүл өөр хүнийг нэр дэвшүүлэн Удирдах зөвлөлийн хурлаар батлуулна.

#### **Арванхоёр дугаар зүйл. Гишүүнчлэл**

- 12.1. МАЗХ нь гишүүнчлэлтэй байна. МАЗХ-ны дүрэм, мэрийн хөтөлбөрийг зөвшөөрсөн өмчийн бүх хэлбэрийн байгууллага тэдгээрийн ажиллагсад сайн дураараа МАЗХ-ны гишүүн байж болно.
- 12.2. МАЗХ-той ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын болон олон улсын иргэн, байгууллага, гадаад оронд авто замын чиглэлээр ажиллаж сурч байгаа монгол улсын иргэн гишүүнээр элсэж болно.
- 12.3. Монголд авто замын чиглэлээр ажиллаж байгаа гадаадын болон хамтарсан компанийд ажиллаж байгаа монгол улсын харьят иргэд гишүүнчлэлд хамрагдаж болно.
- 12.4. МАЗХ нь жинхэнэ болон хүндэт гишүүдээс бүрдэнэ.
- 12.5. Хүндэт гишүүнээр элсүүлэх асуудлыг МАЗХ-ны удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 12.6. Гадаад орны хуулийн этгээд, иргэдийг тус МАЗХ-ны хүндэт гишүүнээр өргөмжлөн бүртгэж болно.

#### **Арвангурав дугаар зүйл. МАЗХ-ны гишүүдийн бүрэн эрх**

- 13.1. МАЗХ-ны гишүүн нь дараах эрхийг эдэлнэ.
  - 13.1.1. МАЗХ – ны удирдах байгууллагад сонгох, сонгогдох
  - 13.1.2. МАЗХ-ны удирдах байгууллагын үйл ажиллагаа, авто замын салбарын тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд идэвхтэй оролцож, үзэл бодлоо илэрхийлэх.
  - 13.1.3. Хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасны дагуу эрхээ хамгаалуулах, дэмжлэг туслалцаа хүсэх
  - 13.1.4. Өөрийн хүсэлтээр МАЗХ-ны гишүүнчлэлээс татгалзах
- 13.2. МАЗХ ны гишүүн дараах үүрэгтэй.
  - 13.2.1. Монгол улсын хууль, энэ дүрмийн шаардлагыг сахин биелүүлэх.
  - 13.2.2. Тогтоосон журмын дагуу жил бүр татвар төлөх ба хандив өгөх.
  - 13.2.3. МАЗХ-ны удирдах байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох.
  - 13.2.4. Залгамж үеэз бэлтгэхэд биет туслалцаа үзүүлэх.
- 13.3. Энэхүү дүрэмд заасан гишүүний эрх, үүрэг нь зөвхөн жинхэнэ гишүүнд хамаарна.

#### **Арвандөрөв дүгээр зүйл. Гишүүнээр элсэх болон гарах журам**

- 14.1. МАЗХ-ны гишүүнээр элсэхийг хүсэгч иргэн, хуулийн этгээд нь гишүүдэд тавих шаардлагуудыг хүлээн зөвшөөрснөө батлан гишүүнээр элсэх тухай өргөдөл гаргаснаар элсүүлнэ.
- 14.2. Гишүүнээр элсүүлэхээс ямар нэгэн шалтгаангүйгээр татгалзаж болохгүй.
- 14.3. Гишүүнээр элсэгч хүсэлт гаргагч нь удирдах зөвлөлийн гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гарсанаар МАЗХ-ны жинхэнэ гишүүн болно.
- 14.4. Дараах тохиолдолд гишүүнээс гарна.
- 14.4.1. Гишүүн нь МАЗХ-ны гишүүнээс гарахтухай хүсэлт гаргасан
  - 14.4.2. З сарын турш гишүүний татвараа төлөөгүй
  - 14.4.3. МАЗХ-ны дүрмийг удаа дараа / 2 ба түүнээс дээш/ зөрчсөн
  - 14.4.4. МАЗХ-ны дүрмийг ноцтой зөрчиж тэр нь МАЗХ-ны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг ямар нэг байдлаар хөндсөн
- 14.5. Гишүүн нь МАЗХ-ны гишүүнээс гарах хүсэлтээ удирдах зөвлөлд бичгээр гаргана.
- 14.6. Удирдах зөвлөл тухайн хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 14.7. Ямар нэг шалтгаангүйгээр гишүүнээс гарах хүсэлтийг шийдвэрлэхгүй байж болохгүй.
- 14.8. Удирдах зөвлөлийн санаачилгаар гишүүнээс гарах тохилдолд удирдах зөвлөл ямар зөрчлийн улмаас гишүүнээс хасч буйг тодорхой дурьдсан үндэслэл бүхий тогтоол гаргана.
- 14.9. Гадаад орны хуkdпийн этгээд, иргэдийг тус МАЗХ-ны хүндэт гишүүнээр өргөмжлөн бүртгэж болно.



#### **Арвантав дугаар зүйл. МАЗХ-ны санхүүгийн эх үүсвэр**

- 15.1. Санхүү нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 15.1.1. Гишүүний татвар, хандив
  - 15.1.2. Гишүүд, гадаад, дотоод дэмжигч байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусlamж. гэрээслэлийн өв хөрөнгө. төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө
  - 15.1.3. Төсөл хэрэгжүүлсэнээс олсон орлого
  - 15.1.4. Зорилгоо хэрэгжүүлэхээр явуулсан аж ахуйн, үйл ажиллагаанаас олсон орлого

#### **Арванзургаа дугаар зүйл. Холбооны санхүү**

- 16.1. Санхүүгийн тайлан гаргах хугацаа нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу 1-р сарын 1-нд эхлэн 12-р сарын 31-нд дуусгавар болно.
- 16.2. Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал нь МАЗХ-ын жилийн төсвийг гарган Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна.
- 16.3. МАЗХ нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.
- 16.4. Гишүүдээс авах татварын хувь хэмжээг зөвлөлдөх хорооны хурлаас тогтоож мөрдүүлнэ.
- 16.5. МАЗХ нь санхүүжилгээ хэвийн байлгах зорилгоор сургалт явуулах, зураг төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, хэвлэл гаргах ажил үйлчилгээ явуулж болно.
- 16.6. Засгийн газрын байрууллагуудтай тохиролцож төрийн зарим үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх, мэргэжлийн зөвлөлгөө дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ, зураг төсөл боловсруулах нэгжийг дотоод тооцоогоор ажиллуулж болно.

- 16.7. МАЗХ-ны хөрөнгийн (ашиглалт, эзэмшилт, мөнгөн хөрөнгийн орлого зарцуулалтад их хурлаас сонгогдсрон З хүний бүрэлдэхүүнтэй хяналтын зөвлөл жилд нэгээс доошгүй удаа шалгалт хийж дүнг зөвлөлдөх хорооны хуралд оруулан хэлэлцүүлэх.
- 16.8. Удирдах зөвлөлийн гишүүн, ажилтнаас МАЗХ-ны хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 16.9. Дүрэмд зааснаас өөр ажил үйлчилгээ явуулж ашиг олох, алдагдалтай ажил үйлчилгээ эрхлэх, цэвэр бизнесийн шинж чанартай үйл ажиллагаа эрхэлж болохгүй
- 16.10. МАЗХ-ын эд хөрөнгийг хувь хүн аль нэг байгууллагад ашиг олох зорилгоор ашиглуулахыг хориглоно.
- 16.11. Өөрийн хөрөнгийн зарцуулалтыг оновчтой болгох зорилгоор тусгай сан байгуулан ажиллаж болно.
- 16.12. МАЗХ-ны хөрөнгийг шүүхийн шийдвэргүйгээр хураах, дайчлахыг хориглоно.

#### **Арвандолдугаар зүйл .Төрийн болон ТББ-тай харьцах журам**

- 17.1. Төрөөс хараат бус байж хуульд заасны дагуу эрхээ хамгаалуулна.
- 17.2. МАЗХ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу салбарын өмнө тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, энэ дүрмийн 5.4-д заагдсан үүргийг гүйцэтгэвэл төрөөс санхүүжилт болон бусад хэлбэрийн дэмжлэг авах эрхтэй.
- 17.3. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас салбарын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах болно.
- 17.4. Шаардлагатай гэж үзвэл төрийн болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтарсан шийдвэр гаргаж болно.
- 17.5. Салбарын болон гишүүдийн эрх ашгийг илт хохироосон буруу шийдвэрийг төр засгийн байгууллага, албан тушаалтан гаргавал байр сууриа илэрхийлэх, шүүмжлэх, түүнийг өөрчлүүлэх, хүчингүй болгох, засуулах талаар шаардлага тавих, мэдэгдэл гаргах, улмаар эсэргүүцлийн арга хэмжээг хуульд нийцүүлэн зохион байгуулах эрхтэй.
- 17.6. Салбарын ТББ-уудтай ажил төрлийн байнгын холбоотой хамтран ажиллаж, тохиролцсон асуудлаар хамтын шийдвэр гаргаж, үйл ажиллагааг хамтран зохион байгуулж болно.
- 17.7. МАЗХ нь Зөвлөлдөх хорооны шийдвэрийг үндэслэн Монгол улсад ажиллаж байгаа бусад холбоо, нийгэмлэгт гишүүнээр элсэж болно.
- 17.8. МАЗХ нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг төрийн холбогдох байгууллагуудад хугацаанд нь гаргаж өгч байна.

#### **Арваннайм дугаар зүйл. Татан буулгах**

- 18.1. МАЗХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Их хурлаар шийдвэрлэнэ.
- 18.2. Адил төстэй чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагатай нэгдэх, нийлэх асуудлыг Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 18.3. Холбоо нь өргөжиж, дагнан тусдаа үйл ажиллагаа явуулах шинэ ТББ-ыг тусгаарлах, салах зэргээр өөрчлөгдөн байгуулагдаж болох бөгөөд энэ асуудлыг Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 18.4. МАЗХ-г хуулийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгах тохиолдолд өр төлбөрийг төлж дууссаны дараа үлдэх хөрөнгийг салбарын ижил төстэй

зорилго бүхий төрийн бус байгууллага, ийм байгууллага байхгүй тохиолдолд салбарын төрийн байгууллагад шилжүүлнэ.

**Арван ес дүгээр зүйл. Холбооны хүлээх хариуцлага**

- 19.1. МАЗХ нь “Төрийн бус байгууллагын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.  
19.2. МАЗХ нь өөрийн гишүүн болон МАЗХ-ны удирдах байгууллагын сонгуультны хууль бус үйл ажиллагаатай холбогдсон эд хөрөнгийн болон бусад хариуцлагыг хүлээхгүй.

**МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБОО**